

## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/185/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a> Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a> Гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа Утас: 99108763, Цахим хаяг: <a href="mailto:uwaauul.audit@gmail.com">uwaauul.audit@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 025

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН  
ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.БАТДЭЛГЭР  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар Сэлбэ дулааны станцын ус, дулаан дамжуулах төвийн 4,189.6 сая төгрөгийн өртөгтэй барилга, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд 16,255.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16,718.9 сая төгрөгийн зардал гарган, 463.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1426050569

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг\Харгал 2025\2026\wordywsan bichig Dugneit\_2026.docx

### **Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	598,771,308.53	589,428,384.25
1.1.2	Дансны авлага	66,349,760.51	129,530,075.28
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	357,000.00	42,330,003.58
1.1.6	Бараа материал	1,522,264,090.33	1,395,523,635.22
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,187,742,159.37</b>	<b>2,156,812,098.33</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	37,430,759,824.88	41,261,624,896.73
1.2.2	Биет бус хөрөнгө	420,754,394.10	419,833,035.55
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>37,851,514,218.98</b>	<b>41,681,457,932.28</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,039,256,378.35</b>	<b>43,838,270,030.61</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	3,161,037.89	7,750,735.11
2.1.1.3	Татварын өр	769,153.91	70,169,871.22
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,930,191.80</b>	<b>77,920,606.33</b>
2.1.2.5	Хойшлогдсон орлого	28,795,129,743.86	32,984,760,945.79
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>28,795,129,743.86</b>	<b>32,984,760,945.79</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>28,799,059,935.66</b>	<b>33,062,681,552.12</b>
2.3	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.1	Төрийн өмч	1,097,218,307.26	1,097,218,307.26
2.3.2	Хувийн өмч	-	-
2.3.3	Хувьцаат өр төлбөр	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	637,074,001.39	637,074,001.39
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	14,470,170,123.55	14,470,170,123.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,964,265,989.51)	(5,428,873,953.71)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(603,784,437.65)	(464,607,964.20)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(4,360,481,551.86)	(4,964,265,989.51)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>11,240,196,442.69</b>	<b>10,775,588,478.49</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>40,039,256,378.35</b>	<b>43,838,270,030.61</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,368,218,212.16	6,117,566,996.48
2	Борлуулалтын өртөг	13,277,689,465.95	11,321,027,831.39
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(7,909,471,253.79)</b>	<b>(5,203,460,834.91)</b>
5	Хүүгийн орлого	20,572,013.63	8,402,360.03
8	Бусад орлого	10,594,734,179.09	10,129,203,530.46
8.1	Орлогын дүн	10,615,306,192.72	10,137,605,890.49
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,271,494,758.38	5,346,835,437.61
12	Бусад зардал	12,033,440.00	20,240,000.00
12.1	Зардлын дүн	3,283,528,198.38	5,367,075,437.61
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(24,033,976.83)	(30,837,346.16)
17.1	Олз гарзын дүн	(24,033,976.83)	(30,837,346.16)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(601,727,236.28)	(463,767,728.19)
19	Орлогын татварын зардал	2,057,201.37	840,236.01
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(603,784,437.65)	(464,607,964.20)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(603,784,437.65)	(464,607,964.20)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(603,784,437.65)	(464,607,964.20)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,470,170,123.55	(4,360,481,551.86)	11,843,980,880.34
Залруулсан үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,470,170,123.55	(4,360,481,551.86)	11,843,980,880.34
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	24,938,032,614.36	-	24,938,032,614.36
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(603,784,437.65)	(603,784,437.65)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,470,170,123.55	(4,964,265,989.51)	11,240,196,442.69
Залруулсан үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,470,170,123.55	(4,964,265,989.51)	11,240,196,442.69
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(464,607,964.20)	(464,607,964.20)
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,097,218,307.26</b>	<b>637,074,001.39</b>	<b>14,470,170,123.55</b>	<b>(5,428,873,953.71)</b>	<b>10,775,588,478.49</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>15,874,786,425.08</b>	<b>15,054,893,056.45</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	6,130,575,125.08	6,742,504,277.50
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,744,211,300.00	8,312,388,778.95
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,099,277,590.36	15,072,626,457.56
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,954,867,448.68	3,001,671,234.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,620,238,958.84	1,309,711,628.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,420,811,676.48	8,332,704,523.27
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	116,520,570.90	26,951,879.95
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,435,160.00	124,535,168.19
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	631,612,740.17	498,733,106.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	33,924,561.00	137,700.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	313,866,474.29	1,778,181,216.76
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	224,491,165.28	17,733,401.11
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,572,013.63	8,390,476.83
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,572,013.63	8,390,476.83
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,572,013.63	8,390,476.83
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(203,919,151.65)</b>	<b>(9,342,924.28)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>802,690,460.18</b>	<b>598,771,308.53</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>598,771,308.53</b>	<b>589,428,384.25</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2024	2025 он		Өсөлт/+/- бууралт/-/
	Гүйцэтгэл	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зөрүү
Халаалтын орлого	5,368,218,212.16	6,093,959,170.00	6,117,566,966.48	23,607,796.48
Төсвийн санхүүжилт	9,570,907,300.00	10,446,060,300.00	8,181,980,600.00	(2,264,079,700.00)
Бусад мөнгөн орлого	1,044,398,892.72	8,000,000.00	138,810,568.98	130,810,568.98
Бусад орлого-Элэгдэл	-	-	1,816,814,751.51	1,816,814,751.51
	15,983,524,404.88	16,548,019,470.00	16,255,172,886.97	(292,846,583.03)
ББӨ	-	-	-	-
Түүхий нүүрс	3,231,271,480.00	3,200,000,000.00	1,013,137,675.35	(2,186,862,324.65)
Хийн түлш	702,214,543.00	720,409,500.00	804,744,542.00	84,335,042.00
Мидлинг түлш	-	-	1,764,458,618.80	1,764,458,618.80
Цахилгаан	500,518,055.23	650,673,471.80	689,903,282.40	39,229,810.60
Технологийн ус	125,600,000.00	125,600,000.00	113,791,943.08	(11,808,056.92)
Сэлбэг хэрэгсэл, урсгал засвар	515,949,819.00	398,000,000.00	780,032,612.19	382,032,612.19
Үндсэн ба нэмэгдэл цалин	7,472,726,009.86	8,101,703,500.00	5,799,229,327.50	(2,302,474,172.50)
Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	904,929,125.38	962,378,200.00	721,949,837.35	(240,428,362.65)
Хог хаягдал, цэвэрлэгээ	116,937,119.91	120,000,000.00	214,503,470.39	94,503,470.39
Бичиг хэрэг	20,962,360.00	210,000,000.00	138,652,041.70	(71,347,958.30)
Харилцаа холбоо, интернет	400,156,076.67	410,150,000.00	109,542,040.26	(300,607,959.74)
Хөдөлмөр хамгаалал	135,552,768.52	99,000,000.00	255,226,066.45	156,226,066.45
Элэгдэл	1,428,606,568.17	1,216,904,800.00	2,357,491,710.71	1,140,586,910.71
Ашиглалтын зардал	14,455,972.76	20,000,000.00	5,763,217.25	(14,236,782.75)
Шатахууны зардал	84,077,588.94	97,000,000.00	82,675,673.08	(14,324,326.92)
Томилолт	-	15,000,000.00	-	(15,000,000.00)
Сургалтын зардал	67,460,000.00	68,000,000.00	51,024,672.00	(16,975,328.00)
Зохицуулах үйлчилгээний хөлс	4,634,674.29	10,000,000.00	8,510,700.00	(1,489,300.00)
Гадны үйлчилгээний хөлс/аудит/	7,000,000.00	7,000,000.00	7,000,000.00	-
Аваарын үеийн эрсдлийн нөөц сан	10,000,000.00	10,000,000.00	-	(10,000,000.00)
Бусад зардал	785,727,766.00	40,000,000.00	1,680,994,390.36	1,640,994,390.36
Газрын төлбөр	4,571,120.00	7,500,000.00	6,282,914.66	(1,217,085.34)
ҮХХАТ	14,804,616.86	16,000,000.00	16,692,853.90	692,853.90
АТӨЯХАТ	1,086,977.94	2,000,000.00	4,473,193.00	2,473,193.00

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Банкны шимтгэл	629,000.00	700,000.00	416,900.00	(283,100.00)
Ажиллагсдын нийгмийн зардал	35,380,000.00	40,000,000.00	92,442,932.73	52,442,932.73
Нийт зардал	16,585,251,642.53	16,548,019,471.80	16,718,940,615.16	170,921,143.36
Татвар төлөхийн өмнөх ашиг	(601,727,237.65)	(1.80)	(463,767,728.19)	(463,767,726.39)
Орлогын албан татвар	2,057,200.00	1,000.00	840,236.01	839,236.01
Цэвэр ашиг, алдагдал	(603,784,437.65)	(1,001.80)	(464,607,964.20)	(464,606,962.40)
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.04	1,000.00	-	(1,000.00)
Нийт авлага	60,000,000.00	60,000,000.00	129,530,075.28	69,530,075.28
Нийт өр төлбөр	500,000.00	500,000.00	7,750,735.11	7,250,735.11
Худалдан авалт	102,000,000.00	98,000,000.00	-	(98,000,000.00)
Нийт худалдан авалт	102,000,000.00	98,000,000.00	-	(98,000,000.00)

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 40,703,592.0 мянган төгрөгийн 171 мэдээллийг байршуулахаас 167 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож, таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 11 гүйлгээний 947,278.4 мянган төгрөг, зарлагын 2 гүйлгээний 918,086.7 мянган төгрөг, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл огт байршуулаагүй байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.5-д *“цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”*, 6.10-т *“Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг мөрдөөгүй, төсөвт өртгийг хувааж 901,140.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”*, 10 дугаар зүйлийн 10.3-д *“Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 113 ширхэг 1,106,400.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”*, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д *“төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”*, Төрийн аудитын тухай хуулийн 20

дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Харилцагч 8 байгууллагын 5,970.3 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Бараа материалын зарлагыг анхан шатны баримтаар баталгаажуулж тухай бүр бүртгэдэггүй, нүүрсний жингийн хуудас, хүлээн авалтын акт, агуулахын бүртгэл зэрэг үндсэн баримтууд хөтлөгдөөгүй байна. Мөн зарлагын баримтыг хугацаа хоцроож бүртгэдэг, хүлээн авсан ажилтнаар баталгаажуулаагүй, засвар үйлчилгээтэй холбоотой ажлын даалгавар болон гүйцэтгэлийн актгүйгээр нийт 125,475.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын зарлагыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгээр баталгаажаагүй, тухай бүр зарлагадаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-1: Жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй, шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 10,300.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудсыг бүрэн, үнэн зөв хөтлөх, шатахууны зарцуулалтын тайланг тогтмол гаргаж баталгаажуулах, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Харилцагч 8 байгууллагын өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	5,970.3	-	-	1	5,970.3								
2	Бараа материалын зарлагын анхан шатны баримтын бүрдэл дутуу, засвар үйлчилгээ хийсэн нотлох баримт байхгүй	1	125,475.0	-	-	1	125,475.0	-	-						
3	113 ширхэг 1,106,400.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-	-	-	1	-								
4	Жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй, шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй шатахуун зарцуулсан	1	10,300.0	-	-			1	10,300.0						
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>141,745.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>131,445.3</b>	<b>1</b>	<b>10,300.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 4, Таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 11 гүйлгээний 947,278.4 мянган төгрөг, зарлагын 2	1	1,865,368.7	-	-	-	-	1	1,865,368.7

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

гүйлгээний 918,086.7 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,865,369.7</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>1,865,369.7</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийсэн байна.	1	901,140.2			1	901,140.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>901,140.2</b>	-	-	<b>1.00</b>	<b>901,140.2</b>	-	-
<b>НИЙТ</b>	<b>2</b>	<b>2,766,508.9</b>	-	-	<b>1.00</b>	<b>901,140.2</b>	<b>1</b>	<b>1,865,368.7</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 307/20810599

Улаанбаатар хот

НТАГ-2026/185/НА-СТА-0109/1

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын зарлагыг анхан шатны баримтаар баталгаажуулж тухай бүр бүртгэдэггүй, нүүрсний жингийн хуудас, хүлээн авалтын акт, агуулахын бүртгэл хөтлөгдөөгүй, зарлагын баримтыг хугацаа хоцроож бүртгэдэг, хүлээн авсан ажилтнаар баталгаажуулаагүй, засвар үйлчилгээтэй холбоотой ажлын даалгавар болон гүйцэтгэлийн актгүйгээр нийт 125,475,050.00 (нэг зуун хорин таван сая дөрвөн зуун далан таван мянга тавь) төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.4-д "Аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын зарлагыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй зарлагадсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Л.Батдэлгэр, ерөнхий нягтлан бодогч Б.Одцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Ч.МӨНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090532



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 308/20810579

Улаанбаатар хот

НТМ-2026/185/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 901,140,238.00 (есөн зуун нэг сая нэг зуун дөчин мянга хоёр зуун гучин найм) төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар 1-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Л.Батдэлгэр, ерөнхий нягтлан бодогч Б.Одцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Ч.МӨНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090523



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 309/20810579

Улаанбаатар хот

НММ-2026/185/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагч 8 байгууллагын 5,970,347.00 (таван сая есөн зуун далан мянга гурван зуун дөчин долоо) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагчтай өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар3-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Л.Батдэлгэр, ерөнхий нягтлан бодогч Б.Одцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Ч.МӨНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426990527



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 510/2026.05.15

Улаанбаатар хот

НТАГ-2026/185/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 113 ширхэг 1,106,400,012.00 (нэг тэрбум нэг зуун зургаан сая дөрвөн зуун мянга арван хоёр) төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7-д "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар<sup>2</sup>-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын дарга Л.Батдэлгэр, ерөнхий нягтлан бодогч Б.Одцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Ч.МӨНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090525